



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/27

Хэрлэнбаян-Улаан тосгон

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 25 дугаар зүйлийн 25.1, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4, 3.4.3, 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус тосгонд 2024 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх “Дотуур байрны хүүхэд хөгжлийн танхимын засварын материал” худалдан авах гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	С.Отгонбаяр	- Захирагчийн ажлын албаны дарга
Гишүүд:	Н.Ганцэцэг	- Захирагчийн ажлын албаны нярав
	Н.Аззаяа	- ЕБСургуулийн нярав

2. “Дотуур байрны хүүхэд хөгжлийн танхимын засварын материал” худалдан авах гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай

ЗАХИРАГЧ



Ж.МАРТ